



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/40

Санхүүцэлгүй

Хорио цээрийн дэглэмийг цуцалж
Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 32 дугаар зүйлийн 32.1.4, 32.1.7, 32.1.8 дахь заалт, "Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврын 2.5.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Голомт болон сэжигтэй бүсэд сүүлийн 28 хоногийн дотор өвчний тохиолдол дахин илрээгүй тул мал эмнэлгийн улсын байцаагчийн саналыг үндэслэн хорио цээрийн дэглэмийг цуцалж, хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Гоц халдварт мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг онцгой комиссын орлогч дарга (Г.Энхдэлгэр)-т даалгасугай.

3. Хязгаарлалтын бүсэд байгаа малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, ариутгал, халдваргүйжүүлэлт хийж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (О.Буянбаатар), 5-р багийн Засаг дарга (Д.Ууганбаяр) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ард иргэд, малчдыг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Базаррагчаа), Тархвар зүйч (Т.Машбат) нарт үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА

4023020079